



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 01/95


Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1, Онцгой комиссын 2017 оны 02 сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 2016-2017 оны өвөл 20 гаруй удаа бороо цас холилдон орсны улмаас цасны зузаан тал хээрийн бүсд 19-25 см, шуурч хунгарласан газартаа 30-60 см-т хүрч байнга явган шуурга шуурч зам даваа хаагдан, зорчигчид цасанд суусан дуудлагаар сум орон нутгаас туулах чадвар сайтай автомашинуудыг дайчлан ажиллуулж иргэдийн амь нас, эд хөрөнгийг аврах ажиллагааг зохион байгуулах явцад зарим сум, тосгоны автомашинууд эвдэрч зайлшгүй засварлах шаардлагатай болсон тул зардлыг тооцож олгосугай.
- Сумдын нэр, зардлын төрөл, мөнгөн дүнг хавсралтаар баталсугай.
- Техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулахад шаардагдах 10860000 /арван сая найман зуун жаран мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.
- Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2017 оны
03 дугаар сарын 07 өдрийн
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН НЭР, ТӨРӨЛ

| д/д | Байгууллагын нэрс | Сэлбэг | Дүн /төгрөг/ |
|-----|-------------------|----------|--------------|
| 1 | Батноров | 2500000 | 2500000 |
| 2 | Хэрлэн | 2000000 | 2000000 |
| 3 | Бэрх | 3360000 | 3360000 |
| 4 | Гурван баян | 3000000 | 3000000 |
| | Бүгд | 10860000 | 10860000 |